



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тариат сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/08-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn
2025 он	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	8
5. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ	9

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.04 № 156
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ТАРИАТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА Н.ЧИНБАТ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн "Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай" А/723 дугаар тушаалаар сумын ойгоос үйлдвэрлэлийн зориулалтаар хуш модны самар түүж бэлтгэх дээд хэмжээг 98,000 кг байхаар тогтоож, тайлант онд 535,310.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс 237,425.0 мянган төгрөгийг сумын төсвийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, соёл

урлаг, ерөнхий боловсрол, эрүүл мэндийн бодлого удирдлага, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зориулан 2,832,715.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,534,622.3 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 298,092.7 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Үүнээс 190,708.4 мянган төгрөг нь ОНХС, ХХС-ийн зарцуулагдаагүй үлдэгдэл бол 107,384.3 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн төсвийн үлдэгдэл байна.

Сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС-ийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, ЕБС, Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн тогтмол зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэгтгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2024 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран 15 үндсэн зорилтын хүрээнд 105 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 80.5 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	917,590.7	1,197,656.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	421,492.8	675,951.9
33	АВЛАГА	418,563.6	442,837.7
35	БАРАА МАТЕРИАЛ	77,534.3	74,233.3
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	4,634.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,137,803.8	3,321,907.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,137,803.8	3,321,907.3
39200	Биет хөрөнгө	3,101,151.6	3,284,955.1
39300	Биет бус хөрөнгө	36,652.2	36,952.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,055,394.5	4,519,564.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	24,423.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	24,423.2
41300	Өглөг	0.0	24,423.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,055,394.5	4,495,140.9
51	Засгийн газрын хувь оролцоо	4,055,394.5	4,495,140.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	377,027.4	377,027.4
51200	Хуримтлагдсан үр дүн	3,313,946.0	3,753,692.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	364,421.1	364,421.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,055,394.5	4,519,564.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,318,005.5	3,327,454.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	603,902.3	1,056,637.0
110	Орлогын албан татвар	371,434.3	756,599.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	371,298.3	756,499.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	136.0	100.0
113	Хөрөнгийн албан татвар	116,182.6	102,154.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	116,285.3	197,883.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	391,224.2	696,468.3
120	Нийтлэг татварын бус орлого	391,224.2	696,468.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,322,879.0	1,574,349.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,049,509.0	2,485,339.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,049,509.0	2,465,339.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,985,195.3	2,387,525.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,732.8	801,141.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,312.9	97,804.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,498.2	652,662.2
2104	Хангамж, бараа материалын зардал	68,468.4	55,296.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,212.5	157,051.8
2107	Томилолт, зочны зардал	10,578.0	15,270.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	875,109.2	140,269.3

Архангай аймгийн Тариат сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	404,283.2	468,029.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,064,313.7	77,813.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	20,000.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	268,496.5	842,115.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	561,383.1	402,368.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-292,886.6	439,746.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,068,367.10	2,854,349.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	603,902.3	1,056,637.0
110	Орлогын албан татвар	371,434.3	756,599.0
1100	Хувь хүний орлогын албан татвар	371,298.3	756,499.0
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	136.0	100.0
113	Хөрөнгийн албан татвар	116,182.6	103,529.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	116,285.3	196,509.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	40,433.6	44,599.5
1181	Газрын төлбөр	42,520.0	14,489.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	33,331.7	137,419.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	141,585.8	223,362.7
120	Нийтлэг татварын бус орлого	141,585.8	223,362.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,322,879.00	1,574,349.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,701,239.10	2,026,885.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,701,239.10	2,026,885.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,636,925.4	1,949,071.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	511,939.6	801,706.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,141.6	98,401.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,759.6	628,239.0
2104	Хангамж, бараа материалын зардал	66,295.2	51,701.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,220.5	145,019.0
2107	Томилот, зочны зардал	10,578.0	15,142.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	880,433.8	135,451.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,557.1	73,410.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,064,313.70	77,813.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	367,128.0	827,463.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	627,537.0	478,004.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	627,537.0	478,004.5
2200	Дотоод эх үүсвэрээр	627,537.0	478,004.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-627,537.0	-478,004.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-187,000.0	-95,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	187,000.0	95,000.0

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-447,409.0	254,459.1
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	868,901.8	421,492.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	421,492.8	675,951.9

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,348,281.1	4,348,281.1
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,348,281.1	4,348,281.1
3	Тайлант үеийн үр дүн	-292,886.6	-292,886.6
4	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,055,394.5	4,055,394.5
5	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,055,394.5	4,055,394.5
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,055,394.5	4,055,394.5
7	Тайлант үеийн үр дүн	439,746.4	439,746.4
8	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	4,495,140.9	4,495,140.9

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,832,715.0	2,534,622.3	298,092.70	89.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,105,388.1	1,997,253.7	108,134.40	94.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,027,574.2	1,919,439.8	108,134.40	94.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	839,342.6	801,706.0	37,636.60	95.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,855.4	98,401.2	6,454.20	93.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	660,813.3	628,239.0	32,574.30	95.07
2104	Хангамж, бараа материалын зардал	54,932.6	52,001.9	2,930.70	94.66
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	182,500.0	164,451.0	18,049.00	90.11
2107	Томилолт, зочны зардал	15,142.5	15,142.5	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	138,619.5	128,130.0	10,489.50	92.43
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,368.3	31,368.3	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,813.9	77,813.9	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,813.9	77,813.9	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	558,208.4	442,368.6	115,839.80	79.25

Архангай аймгийн Тариат сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	169,118.5	95,000.0	74,118.50	56.17
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,832,715.0	2,503,837.0	328,878.00	88.39
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,312,080.9	2,412,672.6	-100,591.70	104.35
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	520,634.1	91,164.4	429,469.70	17.51
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	183,987.8	-183,987.80	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	153,202.5	-153,202.50	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58.00	58.00	0.00	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	0.00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28.00	28.00	0.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28.00	28.00	0.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,567,558.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,567,558.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,267,558.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,345,259.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,922,299.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,567,558.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,567,558.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 2 зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлжээ.

Аудитаар залруулагдаагүй 2 зөрчилтэй асуудал нь материаллаг бус бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 31,868.1 мянган төгрөгөөс бага байх тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Сумын Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагын үлдэгдлийг тулган шалгахад хүүгийн авлагыг тухай бүр сангийн программд бүртгэж хуримтлуулдаг боловч нягтлан бодох бүртгэлийн программд хүүгийн авлага бүртгэдэггүй, зээл төлөлт хийгдсэн үед үндсэн зээлийн авлага, авлагын зээлийн хүүгийн төлбөрийн журналын бичилт хийж байгаагаас санхүүгийн тайланд авлагын үлдэгдэл зөрүүтэй тусгагдаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4-т “Үнэн зөв байх, 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө”, 14 дүгээр зүйлийн 14.3-т Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ, 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, хүүгийн авлагыг нөхөж бүртгэх арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүүгийн авлага бүртгээгүй	1	0.0			1	0.0
Нийт дүн	1	0.0			1	0.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс	
			Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил				
Тайлант хугацаанд шилэн дансанд 12 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	0	1	0
Дүн	1	0	1	0

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5. НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

/мянган төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс:			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг даргын тамгын газар	4	19,752.7	1	5,583.7	3	14,169.0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	1,382.4	1	1,382.4		
Хоршоо хөгжүүлэх сан	1	0.0			1	0.0
Төсвийн төвлөрүүлэн захирагч	1	0.0			1	0.0
Дүн	7	21,135.1	2	6,966.1	5	14,169.0